



БҮРД СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 322
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030638


Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль"-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН ИТХ-ЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Нэг. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Эрүүл иргэн хөгжлийн тулгуур

1.1.1. Малчид иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

1.1.2. ЭМТөвийн орчин үеийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, эмч мэргэжилтнүүдийн ур чадварыг үе шаттайгаар дээшлүүлнэ.

1.1.3. Иргэдийн тамхи архины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.4. Уламжлалт, сэргээх засах, сувилалын эрүүл мэндийг тасгийг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж үйл ажиллагааг чанаржуулж, өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний чиглэлээр өргөжүүлнэ.

1.1.5. ЭМТ-ийн дотоод гадаад орчны тохижилтыг эрс сайжруулж, хэвтэн эмчлүүлэгсдийн тухтай байдлыг хангана.

1.1.6. Эрүүл мэндийн төвд эмчийн орон сууцны тоог нэмэгдүүлнэ.

1.1.7. Хуучин эмнэлэгийн байрыг халуун, хүйтэн ус ариун цэврийн байгууламжтай болгоно.

1.1.8. ЭМТ-ийн орчин үеийн түргэн тусламжийн автомашинаар хангаж, Эмнэлэгийн гал тогоо, бусад өрөөний тохижилтыг хийж, тоног төхөөрөмжөөр хангана.

1.2. Боловсрол төлөвшил-хөгжлийн гүүр

1.2.1. Цэцэрлэгийн барилгын өртгөлийг хийж цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлнэ.

1.2.2. ЕБС-ийн спорт заал засварлан, сургуулийн болон дотуур байрны орчин нөхцлийг сайжруулж, хүүхэд сурч хөгжих таатай орчин бүрдүүлнэ

1.2.3. Ерөнхий боловсролын сургуулийн анги кабинетийг орчин тоног төхөөрөмж үзүүлэнгээр хангаж хүүхэд хөгжлийн хөтөлбөрүүдийн үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудын авьяас чадварыг нээн хөгжүүлнэ.

1.2.4. Багш боловсон хүчний мэргэжил, боловсрол, ур чадварыг дэмжиж багш нарын хөгжлийн өрөөг тохижуулан, гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, тэдний орон сууцны нөхцлийг сайжруулахад анхаарна.

1.2.5. Шинэ соёлын төвийн материаллаг бааз, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж хөдөөгийн иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээг чанаржуулна.

1.2.6. Сургуулийн болон дотуур байрны хүүхдийн спорт тоглоомын талбайг тохижуулна.

1.2.7. Спорт зааланд их засвар хийж, спор тоглоомын талбайнуудыг байгуулан спортын төрлүүдийг хөгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлж, мэргэжлийн арга зүйчтэй болгоно.

1.2.8. Соёлын биет ба биет бус өвийг хамгаалах шинэ арга барил нэвтрүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1 Үйлдвэрлэл-хөгжлийн гарц

- 2.1.1. Мал аж ахуйн түүхий боловсруулах жижиг үйлдвэрлэлийн дэмжиж ажиллана
- 2.1.2. Олон гишүүнт хоршоололыг хөгжүүлж, бие даасан үйл ажиллагааг ханган, мал аж ахуйг эдийн засагжуулж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.1.3. Малчид иргэдийн сүү, цагаан идээ боловруулж аймаг хотын зах зээлд гаргах идэвхийг дэмжиж ажиллана.
- 2.1.4. Түлээ нүүрс, төрөл бүрийн модон бэлдэц бүхий зах бий болгоно
- 2.1.5. Малчид иргэдийн орлогын судалгаа гаргаж, бага орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж ажиллана.
- 2.1.6. Боригдойн 30 га д тариалалтын хэмжээг бүрэн нэмэгдүүлж, услалтын системийг засварлан ажиллагаанд оруулж үр тариа, хүнсний ногоо, малын тэжээл тариалах, хүлэмжийн аж ахуй бий болгох зэргээр эдийн засгийн эргэлтэнд оруулах
- 2.1.7. Сумын бизнес хөгжлийн төвийн үйлдвэрлэгчдийн орчин үеийн технологи, инвациар хангаж, үйл ажиллагааг тогтворжуулж ажлыг байрын нэмэгдүүлэн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний цахим худалдааг Бүрд бренд цахим сүлжээгээр борлуулах тогтолцоо бүрдүүлнэ.
- 2.1.8. Барилгын материал, блок, явган замын хавтан, брожур, өнгөлгөөний тоосго үйлдвэрлэх ажлыг тогтворжуулна.

2.2. Малчны хот - хөгжил өнгө

- 2.2.1. Малчдын мал маллах арга барил, өвөлжөө, хаваржаа, зусланд амьдрах орчин нөхцлийг сайжруулах төсөлт арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.2.2. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх төсөлт арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.2.3. Малчдад зориулсан ухаалаг шийдэл бүхий мини, хөдөлгөөнт орон сууцыг бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 2.2.4. Хөдөөгийн малчдын амьдралын нөхцлийг эрс сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.2.5. Малчдын мал маллагааны уламжлалт хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг хөгжүүлж хэрэглээнд оруулна.
- 2.2.6. Малын саравч хашаа хороог шинэчлэх, өвөлжөө хаваржааны орчмын бэлчээрийг хашиж хамгаалах ажлыг зохион байгуулна.
- 2.2.7. Уст цэгт, усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авна
- 2.2.8. Тохижилттой сайхан хот айл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.

2.3. Сумын төв - хөгжлийн баталгаа

- 2.2.1. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж авто болон явган хүний зам, замын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, гэр хорооллуудын гудамж талбайн хэсэгчилсэн төлөвлөлтүүдийг сумын онцлогт тохируулан боловсруулж үе шаттай хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.2.2. Сумын төвийн цахилгаан дамжуулах шугамын бүрэн шинэчлэл хийнэ.
- 2.2.3. Цэвэр усны болон ариутгах татуургын нэгдсэн байгууламжийг бий болгож, аж ахуй нэгж, айл өрхийг холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.2.4. Сумын төвийн цахилгаан дамжуулах шугамын бүрэн шинэчлэл хийнэ
- 2.2.5. Сумын төвийн 6 км замыг асфальтан хайрган хучилттай зам болгон сайжруулна



2.2.6. Төвлөрсөн дулаан хангамжийн зуухны шугамын бүрэн шинэчлэлт хийж менежментийг сайжруулна.

2.2.7. Сумын төвийн айл өрх албан байгууллагыг үер усны гамшигаас хамгаалах шинжлэх ухааны үндэстэй арга барил байгууламжийг байгуулна.

2.2.8. Орон сууцны гудамж барих, гэр хорооллын гудамж хашааг цэгцлэн тохижуулж, дулаан хангамж, ус хангамж, бохир усны шинэ шийдлийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.

2.4. Шинэ бүтээн байгуулалт – хөгжлийн ирээдүй

2.4.1. Бүрд сумын төвийг улсын чанартай хатуу хучилттай авто замтай холбох ажлын зураг төсвийг боловсруулан, барьж эхлэнэ

2.4.2. Авто засварын төв, граж, авто угаалгын газартай байгуулна.

2.4.3. Зоогийн газар зочид буудлын үйлчилгээ бүхий худалдааны цогцолбортой болно

2.4.4. Ахуй үйлчилгээний төвийг засварлаж хими цэвэрлэгээ болон бусад үйлчилгээ үзүүлдэг болгоно

2.4.5. Музей, хийдийн барилгыг засварлаж, дулааны шугамд холбох ажлыг хийнэ.

2.4.6. Наадмын талбайг барьж, үндэсний баяр наадмын цогцолбор, иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх төв хэлбэрээр тохижуулна.

2.4.7. Залуучуудын хөгжлийн төвийг халуун ус, бассейнтай болгох

2.4.8. Гэр бүлийн хөгжлийн төв байгуулна.

2.5. Хөдөө аж ахуй-хөгжлийн үндэс

2.5.1. Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг үргэлжүүлнэ.

2.5.2. Мал сүргийн бүтцийг боловсронгуй болгож, үржлийн нэгж байгуулах, чанартай малтай малчдыг урамшуулах тогтолцоог бий болгох,

2.5.3. Өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цехийг үйл ажиллагааг хувийн хэвшлийн оролцтойгоор сайжруулна.

2.5.4. Бэлчээрийг бордох, олон наст ургамал тариалах, хашиж хамгаалах зэргээр бэлчээрийн ашиглалтын менежментийг сайжруулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хийцтэй худаг шинээр барих, засварлах ажлыг үргэлжүүлнэ.

2.5.5. Цөөн малтай, мал маллах сонирхолтой малчин бус өрх болон залуучуудыг төсөл хөтөлбөрт хамруулах.

2.5.6. Нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх.

2.5.7. Олон гишүүнтэй хамтын хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлж улмаар хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл- үйлчилгээг бий болгож ажлын байрыг нэмэгдүүлнэ

2.5.8. Ажлын байр нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.



2.6. Унаган байгаль -хөгжлийн үнэ цэнэ

- 2.6.1. “Эко-Бүрд” ногоон хөгжлийн бодлогыг үргэлжүүлж иргэдийн амарч тухлах, чөлөөт цагаа өнгөрөөх, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн тоог 10 га д хүргэнэ.
- 2.6.2. Гэр хороололын айл өрхийн ногоон байгууламжийг стандартыг бий болгож мөрдүүлнэ.
- 2.6.3. “Алтан шар зам”, “Их монголын гал голомт”, “Их Бүрдийн домог” зэрэг ногоон төгөл байгуулна.
- 2.6.4. Хог хаягдлын орчин үеийн менежментийг бодлого хэрэгжүүлж “ Хоггүй Бүрд” хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж хог хаягдлыг “үнс” “лааз”, “хуванцар” “цаас” “бусад” гэсэн хэлбэрээр ангилах тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.6.5. Булаг шанд гол горхины эхийг 50-100 м хэмжээнд хашиж хамгаалан ногоон байгууламжтай болгох ажлыг эхлүүлнэ.
- 2.6.6. Ан амьтан, байгалийн мод бут, бэлчээр хамгаалах иргэдийн сайн дурын бүлэг байгуулж ажиллана
- 2.6.7. Элсэн тасархай, Их бага Монгол, Ширээт цагаан нуур, Батхаан Дуут манхан, Төв цэгт аялал жуулчлалын үйлчилгээг бий болгож, аялах жуулчдын тоог өсгөж, жуулчдаас орох орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.6.8. Монгол улсын төв цэгийн “ГАЛ ГОЛОМТ ЦОГЦОЛБОР” ийн өргөтгөлийг өргөжүүлж аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Гурав. Иргэдийн оролцоотой төрийн үйлчилгээ

3.1. Төрийн үйлчилгээ -хөгжлийн шалгуур

- 3.1.1. Төрийн албан хаагчдын ёс зүй хариуцлага, ажлын гүйцэтгэлд тулгуурласан шалгуурыг баримтлаж ажиллаж, шударга ёс, авилгагүй, мэргэшсэн төрийн үйлчилгээг дээдлэнэ.
- 3.1.2. Багийн төвийн ажлын байрны ашиглалтыг сайжруулж засварлан Их боригдойн 2 багт багийн байр шинээр барина.
- 3.1.3. Цахим Бүрд бодлогыг хэрэгжүүлж иргэдийг дэмжсэн, нээлттэй, хяналттай, шуурхай төрийн үйлчилгээний тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.1.4. Төрийн байгууллагуудын нэгдсэн стандартын шаардлага хангасан төв агуулах байгуулна.
- 3.1.5. Багийн иргэдийн Нийтийн хурлын үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 3.1.6. Сумын төвд иргэдэд үйлчлэх нэгдсэн төв байртай болж, архив бичиг хэргийн үйлчилгээний шинэ стандартыг хэрэгжүүлнэ.
- 3.1.7. Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгоход чиглэсэн шинэ дэвшилтэт хэлбэрийн үйлчилгээг тууштай нэвтрүүлж, төрийн албаны хяналтын сүлжээг бий болгож, төрийн байгууллагуудыг салбар дундын цахим сүлжээнд бүрэн нэгтгэж, иргэдийн тавьсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг болгох, бүрдүүлэх бичиг баримтын нэр төрлийг цөөлөх, хялбаршуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.1.8. Иргэд, олон нийтийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг нээлттэй ил тодоор хэрэгжүүлэх.



3.2. Хууль хэрэгжилт-хөгжлийн дүрэм

- 3.2.1. Хүний эрх, үүргийн нэгдлийг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарна.
- 3.2.2. Ард иргэдийн дунд нийтийн сонсгол, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, тэдгээрээс гаргасан саналуудыг тухайн гарах шийдвэрт тусгаж, эргэн мэдээлэх асуудлыг журамлаж хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Хүний эрхийг хамгаалах, иргэдийн тэгш оролцоог нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг эрхэмлэсэн төрийн үйлчилгээ үзүүлж, хүүхэд эмэгтэйчүүд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалах чиглэлээр зөвлөгөө өгөх, хамгаалах түр байртай болно.
- 3.2.4. Гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан болсон архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын буруу зуршил зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, дэлхий нийтийн үнэт зүйл, монгол ёс зан заншил, ухамсрыг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэн зөв хүмүүжил олгох ажлыг иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2.5. Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах ажлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг сайжруулж, орон байрын хулгайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хангах чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаа олон нийтийн зөвлөл, нөхөрлөл, бүлгэмийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллана.
- 3.2.6. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинэ техник, технологи, багаж хэрэгслээр хангаж үйлчилгээний байгууллагын стандартыг мөрдөж ажиллана.
- 3.2.7. Гамшиг, байгалын бэрхшээлийн даван туулах шинэ арга барил нэвтрүүлж, малчид иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.2.8 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ шатанд гаргаж, архидалт, тамхилтгүй орчин ажлын байр, айл өрх, хамт олон болох хөдөлгөөнийг дэмжиж, хуулийн хэрэгжилтийг эрс сайжруулна
- 3.3. Тулгамдсан асуудал - хөгжлийн шийдэл
- 3.3.1. Сумын хилийн цэсийг баталгаажуулах ажлыг үе шаттайгаар шийдвэрлүүлнэ.
- 3.3.2. Хот хоорондын тээврийн асуудлыг шийдвэрлэж тогтмолжуулна.
- 3.3.3. Үүрэн телефоны болон интернетийн орчин үеийн шийдлүүдийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ
- 3.3.4. Иргэний нийгмийн байгууллагууд гэр бүл, оюутан, хүүхэд залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийн байгууллага, мэргэжлийн холбоод, сонирхолын хобби бүлгүүдийг бие даан үйл ажиллагааг дэмжиж төсөл хөтөлбөрт хамруулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.3.5. Залуучуудад зориулсан орон сууцны гудамж хороолол барих ажлыг эхлүүлнэ.
- 3.3.6. Залуу гэр бүлийг дэмжсэн зорилтот арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.3.7. Зорилтот бүлгийн иргэдийн хашаа байшин, гэр орон сууцны нөхцлийг сайжруулна.
- 3.3.8 Уламжлалт мал маллах арга ухааны залуу хойч үед өвлүүлэх ажлыг зохион байгуулж залуу малчдыг бэлтгэх ажлыг зохион байгуулна.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН

МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

